ӨМЧИЙН ХЯНАЛТ, АШИГЛАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ш.ДАРЬСҮРЭНГИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" (ЧИГ ҮҮРЭГ)** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1<br>Хяналт, шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, тухайн жилийн турш төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийх | Төлөвлөгөөний Хэрэгжилтийн хувь | 100% | 40% | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/336 дугаар захирамжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тухай удирдамжийг газрын даргаар батлуулж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллав.<br>Тус захирамжаар 4 байгууллагын 168 ширхэг тээврийн хэрэгсэлийг сэлбэг буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсан орлого 43,680,000 төгрөгийг тухайн байгууллагатай холбогдон нийслэлийн төсөвт төвлөрүүллээ.<br>Авто тээврийн үндсэний төвд 2024 оны 02 дугаар сарын 28-ны 4/322 тоот лавлагаа мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсний бөгөөд Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ- данснаас хасагдсан 5 тээврийн хэрэгсэл иргэний нэр дээр бүртгэлтэй хөдөлгөөнд оролцож байгааг тогтоон танилцуулсан.<br>Мөн нийслэлийн Нийтийн тээврийн газар, Мэргэжлийн хяналтын газрын балансад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүд хаана байгаа эсэх нь тодорхойгүй, орлого төвлөрүүлээгүй байдлыг тогтоож Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газарт тээврийн хэрэгсэл эрэн сурвалжлуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоон байгууллагад учруулан хохиролыг барагдуулах тухай | 01.01-12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024.03.07-ны өдрийн 4/414, 2024.03.15-ны өдрийн 4/457 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>Тус тээврийн хэрэгслүүдтэй холбогдуулан Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хөрөнгө хариуцсан ахлах зохион байгуулагч, Аж ахуй хариуцсан ахлах зохион байгуулагч, хөрөнгө хариуцсан зохион байгуулагч, жолооч нарын 2023 оны жилийн эцсийн тайланд шалгалт хийж, хуулийн мэргэжилтнийг байлцуулан газрын даргын өөрөөнд сонсох ажиллагааг зохион байгуулсан. | | |
| | | - | - | - | Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын хурлын шийдвэрээр актлаж данснаас хассан, татан төвлөрүүлж худалдан борлуулаагүй газрын даргын 2023 оны А тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж 420,055,970.2 (дөрвөн зуун хорин сая тавин таван мянга есөн зуун дал) төгрөгийн анхны бүртгэлийн үнэ бүхий 23 байгууллагын 69 нэр төрлийн хөрөнгийн жагсаалтыг гаргаж газрын даргад танилцуулав. | - | 100% |
| | | - | - | - | Газрын даргын 2024 оны А/77 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу Багануур дүүрэгт байрлах Хишиг Уул ХК-ийн (нийслэлийн мэдлийн 34% хувьцаа) үйл ажиллагаатай танилцан хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын илэрсэн зөрчил, ажлын дүгнэлт бүхий тайланг удирдлагад танилцуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Татварын ерөнхий газарт Хишиг уул ХК-ийн татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтэд холбогдох хууль, журмын дагуу татварын хяналт шалгалт хийн, 2003-2023 оны санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгаас нийслэлийн мэдлийн 34 хувьд ногдол ашгийн хэмжээг тогтоон өгөх хүсэлтийг хүргүүлсэн. | - | 100% |
| | Арга хэмжээ 1.2<br>Байгууллагын тайлан балансст бүртгэлтэй барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Багануур дүүргийн 45 барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтын байдлыг газар дээр нь шалгаж байр талбайд зөвшөөрөлгүй автомат машин, АТМ, киоск байршуулсан зөрчлийг арилгах зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | НИТХ-ын 2023 оны "барилга байгууламж акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай" 129 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/1390 дугаар захирамжаар" Урт цагаан үйлчилгээний төв"-ийн барилгыг нийслэлийн өмч бүртгэлээс хассан. Тус захирамжийн дагуу барилгын буулгах ажлын хүрээнд түрээслэгчийн эд хөрөнгийг бүртгэх, хүлээлгэн өгөх, нүүлгэх, иргэдийн зорчих хэсгийн аюулгүй байдлыг ханган ажиллахад оролцсон. | | 100% |
| 2 | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | - | Налайх дүүргийн Эрдмийн оргил цогцолбор сургуулийн Б байранд 2023-2024 оны хичээлийн жилд Налайх дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр дунд ангийн сурагчдын цайны гал тогооны өрөөг тус дүүргийн Албан бус, насан туршийн боловсролын төвд ашиглуулахаар болсон. Тус төв нь уг өрөө, танхимыг сургалтын зориулалтын дагуу ашиглахгүй боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа талаар албан бичиг ирүүлсний дагуу газар дээр нь очиж үзлэг шалгалтыг хийж үйл ажиллагааг зогсоон 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн дотор хариу мэдэгдэх тухай албан бичгийг хүргүүлэн байр талбайг чөлөөлүүлэх арга хэмжээг авч ажиллаа. | 01.01-12.31 | 100% |
| | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | - | НД-ийн ЗДТГ-ын төрийн сангийн хэлтэстэй уулзан "Налайх Хангамжийн төв" ОНӨААТҮГ-ийн 2023 оны түрээсийн үлдэгдэл 6.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн. | | 100% |
| | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | - | Баянгол дүүргийн 14 дүгээр хороо, 3 дугаар хорооллын нутаг дэвсгэрт барлах хуучнаар "Монгол Шуудан" ХК-ийн 24 дүгээр салбар байрны түрээслэгч Тэмүүжин групп майнинг ХХК нь байр, талбайг дамжуулан түрээсэлсэн зөрчлийг арилган түрээсийн гэрээг дуусгавар болгох мэдэгдэл хүргүүлсэн. Түрээслэгч иргэд, аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэн, уулзалтыг зохион байгуулан сарын төлбөр 300.0-350.0 мянган төгрөгөөр түрээсийн гэрээ байгуулахаар хэлэлцээр хийсэн. | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - | - | Нийслэлийн өмчит байгууллагуудын данснаас хасах тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааны анхны үнэ болон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах үнэ тогтоох тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээ хийх сонгон шалгаруулах зарыг хэвлэл мэдээллээр нээлттэй мэдээлсэн. Газрын даргын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан комиссын бүрэлдэхүүн "Файн эстимэйт" ХХК-аас ирүүлсэн материалыг хянан хэлэлцээр хийж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 109 тээврийн хэрэгслээс 99 тээврийн хэрэгслийн үнэлгээг НЗДТГ-ын даргын А/159 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн дүгнэлтэд туссан саналтай тулган нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөлд санал оруулсан. | | 100% |
| | | | - | - | Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн 00-30УБО улсын дугаартай тээврийн хэрэгсэл балансаас балансaт шилжүүлэн хүсэлтийн дагуу хөрөнгийг газар дээр нь үзэж НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 7.2.-т заасны актлах, шилжүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэрийн дагуу явагдах үйл ажиллагааг дуусах хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавихыг мэдэгдсэн. | | 100% |
| | | | - | - | Газрын даргын үүрэг болгосны дагуу нийслэлийн Засаг даргын 2024 оны тээврийн хэрэгсэл балансаас балансaт шилжүүлэх тухай А/608 дугаар захирамжийн дагуу нийслэлийн Төр захиргааны бааз ОНӨТҮГ-ын баланст бүртгэлтэй 274.7 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 8 тээврийн хэрэгслээс БГД-ийн ЗДТГ (1), БХД-ийн ЗДТГ (1), Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ (2), НӨХГ-т (1) зэрэг нийт 201.0 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 5 тээврийн хэрэгслийг актаар хүлээлгэн өгсөн. (актыг ТЗБ-ын ашиглалтын инженер авсан болно. | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - | - | Нийслэлийн Төр захиргааны бааз ОНӨТҮГ-ын данснаас хасах бусад 41 тээврийн хэрэгсэлд "Мэдэгдэл", "Лац хөдлөхийг хориглосон" хуудсыг нааж НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 7.2.-т заасны актлах, шилжүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэрийн дагуу явагдах үйл ажиллагаар дуусах хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавихыг тус баазад мэдэгдсэн. | | 100% |
| | | | - | - | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглалтын дүрмийн шаардлага хангахгүй болсон нь тогтоогдсон барилгад эмийн үйлдвэрлэл явуулж байсныг нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хяналт шалгалтын газарт гаргасан хүсэлтийн дагуу улсын байцаагч томилуулан Эрүүл мэндийн газрын Улсын байцаагчийн 2024 оны 10-13-02/063/003 дугаар дүгнэлтээр 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн түр зогсоон, Хяналт шалгалтын газрын Улсын ахлах байцаагчийн 2024 оны 22-113-01/027/41 дүгнэлтэд Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад нийцэхгүйг үндэслэн тус байгууллын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож эрх бүхий албан тушаалтны авсан эрх хязгаарлах арга хэмжээг хүчинтэйд тооцох тухай саналыг нийслэлийн Прокурорт хүргүүлсэн байна. | 01.01-12.31 | 100% |
| | | | - | - | Нийслэлийн өмчийн харилцааны газрын эзэмшиж буй 28-н байршлын нэгж талбар бүрийг мэдээллийн сангийн бүртгэлтэй тулган шалгаж 2023 онд 24,136,555.0 төгрөгийн татвар төлөхөөс 13,536,514 төгрөгийн газрын төлбөр төлсөн мэдээллийг PPD бэлтгэн газрын даргад танилцуулсан. | | 100% |
| **Зорилт 2 . Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"** | | | | | | | |
| 6 | Арга хэмжээ 2.1<br>Байгууллагын дагаж мөрдөж байгаа салбарын хууль, тогтоол, дүрэм, журмуудад | Эрх зүйн актын тоо | 100% | 0% | НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам", 65 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийн эд | 01.01-12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлэх | | | | хөрөнгийг түрээслүүлэх журам", "Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам"-ын хяналт-шинжилгээ хийн, хэрэгжилтийн явц үр дүнгийн талаарх тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг НЗДТГ-т хүргүүлсэн. | | |
| **Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт - төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгох** | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 3.1<br>Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх | Албан бичиг Өргөдлийн тоо, хувь | 100% | 50% | Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" системээр нийт 125 албан бичиг ирж хугацаанд нь шийдвэрлэж ажилласан бөгөөд 30 албан бичгийг боловсруулж аж ахуйн нэгж байгууллага болон иргэнд хүргүүлсэн байна. | 01.01-12.31 | 100% |
| 9 | Арга хэмжээ 3.2<br>ERP системийн өргөдөл гомдлын программаар иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдол, бусад байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн албан бичиг шийдвэрлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 50% | Тайлант хугацаанд иргэнээс **1** өргөдөл гомдол ирсэн бөгөөд хугацаанд нь **100%** шийдвэрлэсэн. | 01.01-12.31 | 100% |
| 10 | Арга хэмжээ 3.3<br>Хэлтсийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын шаардлагатай мэдээллийг хүргүүлж байгууллагын цахим хуудсанд байршуулах | Мэдээллийн тоо | 100% | 0% | Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу байгууллагын цахим хуудасны 2023 оны мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийхэд дундаж гүйцэтгэл 65%-тай үнэлэгдэж мэдээг НЗТГТ-т хүргүүлсэн. | 01.01-12.31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхлэх, дуусах хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрсэн түвшин | Биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>"Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн үйл ажиллагаар зохион байгуулахад оролцох | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын аж ахуйн зориулалтаар ашиглаж байсан Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 3946мкв газар, 2 дугаар хороонд байрлах Анан ӨЭМТ-ийн хуучин байрны 496 мкв газрыг байгууллагад эзэмшүүлэх тухай 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 4/475 тоот албан бичгийг хүргүүлсэн. "Газар эзэмших, ашиглах эрх олгохыг хянан шийдвэрлэх зөвлөл"-ийн 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/495 дугаар захирамжаар оффис, албан конторын болон аж ахуйн хашаа, агуулахын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн.<br>Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Товчооны зам 1-03 тоотод байрлах 1351 мкв талбайтай нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын аж ахуйн зориулалтаар ашиглаж байсан Богдхан уулын тусгай хамгаалалтын газрын хязгаарлалтын бүсэд хамаарч байсан газрыг ашиглах талаар "Байгаль орчин, аялал жуулчлалын яам"-нд уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлэх талаар" Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 4/377 тоот албан бичиг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн Бодлого зохицуулалтын газарт 2024 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 4/671 тоот албан бичгийг хүргүүлэн хязгаарлалтын бүсэд газар ашиглуулах зөвлөлийн хурлаар дэмжигдээд байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/921 дүгээр захирамжаар Сонгинохайрхан | 01.01-06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүүргийн 13 дугаар хороонд байрлах 1800300481 нэгж талбарын дугаартай 500мкв газрыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт 15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-2201038038 дугаарт бүртгэж гэрчилгээ олгосон газрыг нийслэлийн Өмчийн харилцааны газарт шилжүүлэх тухай 2024 оны 03 дугаар сарын 15-ны 4/395 дугаар албан бичгийг нийслэлийн Газар зохион байгуулалтын албан хүргүүлсэн. Тус албаны дэргэдэх "Газар эзэмших, ашиглах эрх олгохыг хянан шийдвэрлэх зөвлөл"-ийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн №9 дүгээр хурлаар хэлэлцүүлэн тус газрыг нийтийн эзэмшилд шилжүүлэх дүгнэлт гарсан байна.<br>Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 1198мкв талбайтай, 1461704536 нэгж талбарын дугаартай газарт 3 болон 4 давхар 2 орон сууцны барилга баригдаж байгааг газар дээр нь очиж шалган, орон сууцны барилгын зураг төсөл, холбогдох шийдвэрүүдийн ирүүлэх тухай Хот байгуулалт хөгжлийн газарт 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 4/473 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>Хот байгуулалт хөгжлийн газраас дээрх байршилд Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1184 дугаартай захирамж бүхий түр суурьшуулах орон сууцны зориулалтаар олгосон газрыг үндэслэн Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын нэр дээр 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ГБМЗХ2019/19-014 дугаартай "Түр суурьшуулах орон сууц" зориулалттай 3-4 давхар 2 блок барилгын Архитектур төлөвлөлтийн даалгавар, 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр барилгын загвар зураг батлагдан тухай хариуг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 06/681 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн.<br>Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11/67 дугаар "Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай" тогтоолын 2 дугаар хавсралтын 1.13-т "15-р хороо, Дамбадаржаа 81 дүгээр гудамжийг доод Салхит 11 дүгээр гудамжтай холбосон төмөр бетон гүүр"-ийн барилга угсралтын ажлын тендерт "ЗМЗ" ХХК шалгарч барилга угсралтын ажил эхлүүлэх явцад тус ажлын автозамын | | |